

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

АУДИТЫН ДЭД ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорнод аймгийн Аудитын газар

АГУУЛГА

Агуулга	2
Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Аудит хийх хугацаа	4
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	4
Тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	5
Аудитад шаардагдах нөөц	5

Хавсралт №1 Сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл

Хавсралт №2 Аудитын дэд хөтөлбөр

Хавсралт №3 Аудит гүйцэтгэхэд шаарлагатай хөрөнгийн тооцоо,судалгаа

БАТЛАВ: ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

АУДИТЫН ДЭД ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.02.10

Хэрлэн сум

1. Аудитын нэр: Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

2. Аудитын код: УАГ-НАГ/2017/НА-01

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, УАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт: ОНХС-гийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийнэ. Үүнд:

- ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн эсэх.
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх.
- ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэсэн эсэх.
- ОНХС-гийн судалгаа № 1-5, санал асуулга 1

5. Хамрах хүрээ: Аудитад ОНХС хариуцсан төрийн байгууллагуудыг /Аймаг, сумдын ИТХ, аймаг, сумдын ЗДТГ, ХБТХ, аймаг, сумдын СТСХ, аймгийн Өмчийн газар, багийн ИНХ, болон бусад/ хамруулж, ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд Дорнод аймагт хэрэгжүүлэх төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзнэ.

6. Үндсэн мэдээлэл: Дорнод аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2016 оны эцсийн байдлаар аймгийн төв, 14 сумдад нийт 4.1 тэрбум төгрөгийг ОНХС-гаар дамжуулан төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн байна.

7. Эрсдлийн үнэлгээ: Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдлийг 'ДУНД' гэж үнэлсэн.

8. Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, шилдэг арга туршлагатай харьцуулах, цуглуулсан судалгааны баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглана.

9. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам
- Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан “Тендерийн жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай”
- Бусад эрх зүйн актууд

10. Аудит хийх хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2016 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэх ба талбарын ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр дуусгаж, тайланг 04 дүгээр сарын 27-ны дотор ҮАГ-ын НАГ, болон холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорнод аймгийн Аудитын газрын Нийцлийн аудитын баг /Ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч С.Энхбаатар/ гүйцэтгэнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам: Аудитын оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдэнэ.

Аудитын тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар батлуулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлнэ.

13. Аудитад шаардагдах нөөц:

А. Хүний нөөц: 2 хүн – 110 хүн/өдөр

Б. Зарцуулах шатахуун: 866.7 мян төгрөг

В. Зам хоног: 972.0 мян төгрөг

-Нийт зардал: 1838.7 мян төгрөг

-Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видео камер, зургийн аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын дэд төлөвлөгөөг

Хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Д.НАРМАНДАХ


Боловсруулсан:

АХЛАХ ШИНЖЭЭЧ



Ж.БАЯРТУУЛ

ШИНЖЭЭЧ



С.ЭНХБААТАР